

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар....

Улаанбаатар
хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын дэргэд ажиллах нэг талаас ажил олгогч, даатгуулагч, нөгөө талаас нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрөөг хянан шийдвэрлэх “Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрмийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 1994 оны “Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 171 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг